

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2024/001/НА-СТА-ЗГТС**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чойбалсан хот 2025 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	10
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
4. Аудитын тайлан.....	12
4.1 Ерөнхий зүйл .....	12
4.2 Материаллаг байдал .....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
5. Аудитын илрүүлэлт .....	14
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	15

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
НДЕГ	Нийцийн даатгалын ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.03.28 № 439  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОД АЙМГИЙН НИЙГМИЙН  
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА  
Д.АРИУНБОЛД ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой нийгмийн даатгалын байгууллагын салбарын хэмжээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн шинэ систем /SICOC/-ийг нэвтрүүлж байгаатай холбоотой санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд гаргаж ирүүлэхгүй байх нөхцөл байдал үүссэн.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### Бусад асуудал

Дорнод аймгийн Нийгмийн даатгалын газар нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж,

011022227

гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газраас 89.9 хувиар дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Дорнод аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,114,748,116.65	14,610,031,548.68
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,924,498,890.21	10,379,233,040.25
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,924,498,890.21	10,379,233,040.25
31210	Төгрөг	9,924,498,890.21	10,379,233,040.25
31213	Арилжааны банк дахь харилцах	9,924,498,890.21	10,379,233,040.25
33	АВЛАГА	4,190,249,226.44	4,230,798,508.43
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,628,441,670.12	0
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,554,552,776.57	2,556,207,308.57
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0	1,596,721,326.99
33500	Бусад авлага	7,254,779.75	77,869,872.87
33510	Байгууллагаас авах авлага	7,254,779.75	23,762,466.60
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0	54,107,406.27
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	14,114,748,116.65	14,610,031,548.68
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	628,568,049.98	1,490,027,762.36
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	628,568,049.98	1,490,027,762.36
41300	Өглөг	54,665,297.28	560,804,125.17
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	54,665,297.28	0
41360	Бусад өглөг	0	560,804,125.17
41361	Байгууллагад төлөх өглөг	0	17,496,654.56
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0	543,151,061.08
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	0	156,409.53
41400	Урьдчилж орсон орлого	573,902,752.70	929,223,637.19
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	573,902,752.70	929,223,637.19
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,486,180,066.67	13,120,003,786.32
51	Засгийн газрын хувь оролцоо	13,486,180,066.67	13,120,003,786.32
51200	Хуримтлагдсан үр дүн	13,486,180,066.67	13,403,840,810.45
51210	Өмнөх үеийн үр дүн	15,501,736,553.51	13,486,180,066.67
51220	Тайлант үеийн үр дүн	-2,015,556,486.84	-82,339,256.22
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	0	-283,837,024.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	14,114,748,116.65	14,610,031,548.68

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	145,832,608,371.62	197,006,821,719.63
11	ТАТВАРЫН ОРЛОГО	58,978,713,894.64	63,711,239,945.03
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	58,978,713,894.64	63,711,239,945.03
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	40,275,409,121.59	52,788,132,593.60
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,229,901,381.46	5,549,677,257.21
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,523,762,337.12	3,493,018,492.83
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	803,970,349.04	1,880,411,601.39
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	10,145,670,705.43	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	137,670,668.53	142,176,675.58
120	Нийтлэг татварын бус орлого	137,670,668.53	142,176,675.58
120002	Хүүгийн орлого	57,780,855.17	79,033,673.33
120003	Торгуулийн орлого	0.00	5,921,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	41,191,929.36	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	41,191,929.36	0.00
120009	Бусад орлого	38,697,884.00	57,221,602.25

**Дорнод аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	86,716,223,808.45	133,153,405,099.02
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	17,656,337,076.00	36,389,372,267.02
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	17,656,337,076.00	36,389,372,267.02
1330	Төсвийн захирагчдаас	69,059,886,732.45	96,764,032,832.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,059,886,732.45	96,764,032,832.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	147,848,164,858.46	197,089,160,975.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	147,848,164,858.46	197,089,160,975.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,851,430.00	10,487,447.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,851,430.00	10,487,447.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	2,109,767.30
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,851,430.00	8,377,680.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	147,842,313,428.46	197,078,673,528.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	103,332,162,329.00	131,793,251,074.11
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	103,332,162,329.00	131,793,251,074.11
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,510,151,099.46	65,285,422,454.44
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,510,151,099.46	65,285,422,454.44
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-2,015,556,486.84	-82,339,256.22
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,015,556,486.84	-82,339,256.22

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	149,330,359,992.64	210,002,807,240.95
11	ТАТВАРЫН ОРЛОГО	58,573,660,442.76	77,035,455,781.25
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	58,573,660,442.76	77,035,455,781.25
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	40,002,593,070.92	52,662,480,724.05
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,204,235,301.28	5,460,125,055.47
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,492,911,419.10	5,367,409,730.21
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	800,071,827.88	1,924,338,949.90
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	10,073,848,823.58	11,621,101,321.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	132,813,617.43	131,283,127.70
120	Нийтлэг татварын бус орлого	132,813,617.43	131,283,127.70
120002	Хүүгийн орлого	57,769,593.79	79,274,508.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	75,044,023.64	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	75,044,023.64	0.00
120009	Бусад орлого	0.00	52,008,619.04
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	90,623,885,932.45	132,836,068,332.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	21,563,999,200.00	36,072,035,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	21,563,999,200.00	36,072,035,500.00
1330	Төсвийн захирагчдаас	69,059,886,732.45	96,764,032,832.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,059,886,732.45	96,764,032,832.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	147,831,497,859.28	209,548,073,090.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	147,831,497,859.28	209,548,073,090.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,668,070.00	64,726,919.57
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,668,070.00	10,487,447.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	2,109,767.30
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,668,070.00	8,377,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	54,239,472.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	54,239,472.27

**Дорнод аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	147,825,829,789.28	209,483,346,171.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	103,315,678,689.82	131,305,095,066.03
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	103,275,908,223.12	131,305,095,066.03
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,510,151,099.46	78,178,251,105.31
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,510,151,099.46	78,178,251,105.31
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,498,862,133.36	454,734,150.04
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,498,862,133.36	454,734,150.04
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,425,636,756.85	9,924,498,890.21
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,924,498,890.21	10,379,233,040.25

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	15,510,531,322.63	15,510,531,322.63
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-8,794,769.12	-8,794,769.12
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	15,501,736,553.51	15,501,736,553.51
4	Тайлант үеийн үр дүн	0	0	-2,015,556,486.84	-2,015,556,486.84
5	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	13,486,180,066.67	13,486,180,066.67
6	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	0	13,486,180,066.67	13,486,180,066.67
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-283,884,625.16	-283,884,625.16
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	13,202,295,441.51	13,202,295,441.51
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-82,339,256.22	-82,339,256.22
10	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0	0	13,119,956,185.29	13,119,956,185.29

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	135,498,944,100.00	131,305,095,066.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	135,498,944,100.00	131,305,095,066.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,682,300.00	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,682,300.00	0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	7,903,300.00	0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,779,000.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	135,480,261,800.00	131,305,095,066.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	135,480,261,800.00	131,305,095,066.03
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	135,480,261,800.00	131,305,095,066.03
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	135,498,944,100.00	101,555,983,346.77
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	36,072,035,500.00	36,072,035,500.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	36,072,035,500.00	36,072,035,500.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	99,426,908,600.00	65,483,947,846.77
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	99,426,908,600.00	65,483,947,846.77
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл □	0	9,924,498,890.21
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл □	0	10,379,233,040.25

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,103,629.8 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>1</sup> илэрсэнд 3 зөвлөмж өгч, 1 албан шаардлага хүргүүлэн ажиллалаа.

#### 3.1 Албан шаардлага

Нийгмийн даатгалын сангийн зөрүүтэй илэрхийлэгдсэн санхүүгийн тайланг 2025 оны 03 дугаар сарын 09-ний өдөр, 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 126 дугаар албан бичгээр эцэслэн гаргаж Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т "төсвийн төвлөрүүлэн захирагч ..., жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, ..." гэж заасныг зөрчсөнд албан шаардлага хүргүүлэн ажилласан.

#### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Авлага, өр төлбөрийн бүртгэл, тайлагналтай холбоотой

1. Илрүүлэлт: Нийгмийн даатгалын сан нь 1,596.7 сая төгрөгийн 258 аж ахуй нэгж, байгууллагаас авах авлагатай байна. Үүний 25.5 хувь буюу 407.7 сая төгрөг нь 1-ээс дээш жилийн насжилттай байна.

Өгсөн зөвлөмж: Насжилт өндөр авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмж зөвлөмж өгөв.

2. Илрүүлэлт: Өр төлбөр өмнөх оноос 861.3 сая төгрөг буюу 57.8 хувиар өсөж жилийн эцсийн санхүүгийн тайланд 1,490.0 сая төгрөгийг тусгасан байна. Нийт өр төлбөрийн 37.6 хувь буюу 560.8 сая төгрөг нь хувь хүмүүс болон байгууллагад өгөх өглөг эзэлж байна.

Өгсөн зөвлөмж: Өглөгийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөв.

3. Илрүүлэлт: Урьдчилж орсон орлогын дансанд тусгагдсан Сайн дурын датгуулагчийн шимтгэлийн 135.1 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан эсэх нь нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тооцоо нийлсэн актаар баталгаажуулах зөвлөмж өгөв.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл*

*/мянган төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
НДС-гийн авлагын үлдэгдлийн 25% буюу 407.7 сая төгрөг нь 1-ээс дээш жилийн насжилттай байна.	1	407,745.3	-	-	--	-	1	407,745.3	-	-	-	-
Нийт өр төлбөрийн 37.6 хувь буюу 560.8 сая төгрөг нь хувь хүмүүс болон байгууллага д өгөх өглөг эзэлж байна.	1	560,804.1	-	-	-	-	1	560,804.1	-	--	-	-
Урьдчилж орсон орлогын дансанд тусгагдсан Сайн дурын датгуулагчийн шимтгэлийн 135.1 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах	1	135,080.4	-	-	-	-	1	135,080.4	-	-	-	-
Санхүүгийн тайланг хугацаа хоцроон ирүүлсэн.	1	0.0	-	-	1	0.0	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>1,130,629.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>0.0</b>	<b>3</b>	<b>1,130,629.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>